

## ЭРТНИЙ ХЯТАДЫН БУДДЫН ШАШИН БА ХААНТ ТӨРИЙН ХАРИЛЦААНЫ АСУУДАЛД

Ч. Таамаа МУИС, ГХСС. Хятад судлалын тэнхмийн эрхлэгч. Доктор, проф

**Түлхүүр үгс:** Буддын шашны арга ухаан, Хаант төр, Хаант төрийн хууль, чань-буддизм

**Товч агуулга:** Манай эриний заагт хоёр Хан улсын үед Буддын шашин Хятадад анх дэлгэрч, өнө удаан хугацааны хятадын уламжлалт соёл, амьдралын ёс заншилтай зохицон Хятад үндэстэний соёлын чухал нэгэн хэсэг болон хувирсан байдаг. Эдүгээ хүртэл хятадад Буддын сургаал номлол олон мянган сүсэгтэнтэй нөлөө бүхий шашин хэвээр байна.

Хятадын буддын шашны түүх нь өргөн цар хүрээтэй баялаг агуулгатай нягталж судлууштай асуудал ихтэй байдаг юм. Миний бодлоор буддын эрдэм ухаан, хаант төр улсын тухай хаант төрийн хуулийг судлах нь хятадын буддын шашны уламжлал болон онцлогийг ойлгож мэдэхэд чухал ач холбогдолтой, түүнчлэн өнөөгийн олон үндэстний соёлд гадаадын соёлоос суралцах, орчин үеийн буддын шашны хөгжилд судалгааны үнэ цэнэтэй хэрэглэгдэхүүн болно.

Энэ өгүүлэлд буддын шашины түүхэн дэх хамгийн чухал онцлог хэрэг явдлыг нэгтгэж, зарим зарим асуудалд задлан шинжилгээ хийхийг зорив.

**Нэг. Буддын шашны мандал бадрал, уналт доройтлоос буддын шашин болон хаант төрийг харах нь**

Хятадад буддизм анх хэдийд дэлгэрсэн талаар Фэн Ю Лань тэмдэглэхдээ : “Буддизм нь анх Ми Ди хааны засгийн үед / 58- 78 он /хятадад орж иржээ”<sup>1</sup> гэжээ.

Буддын шашны мандал бадрал нь нэн тэргүүнд эрх баригч ангийн ашиг сонирхлын өөрийн хөгжлийн үр дүн юм. Энэ хөгжил нь мөн л эрх

<sup>1</sup> Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ., 2003. 210 дахь тал.

баригч ангитай эргээд зөрчилдөж эсэргүүцэлтэй байнга тулгарч байсан ажээ.

Феодалын нийгмийн үед хятадын зөрчил нь маш хурцадмал, эрх баригч анги дур зоргоор авирлаж, ард олны эрхийг ихээхэн хязгаарлах болсон. Энэ байдал хөдөлмөрчин ардын цөхөрсөн сэтгэлийг ашиглан, ард түмнийг оюун санаагаар хохироодог байлаа. Зүүн Жин улсын үед их сайд Гэн Лиан буддын шашинг эсэргүүцэж, Жин улсын хааны нэрийг барин зарлиг тараан, буддын шашинг шүтэх явдлыг хязгаарлаж байсан түүхтэй. Их сайд хэлэхдээ: "Бурхан байсан байгаагүй нь бидэнд тодорхой биш ээ. Харин гэрээс бичгийг эрж олох нь чухал, таван цээрлэлээс болгоомжилж, хааны үзэл санаанд нийцэх хэрэгтэй" гэжээ. Энэ сайдын үзэл бодлоор, буддын шашинг хөөрөгдсөний хэрэггүй, бурханы сургаалын үнэн худлыг мэдэхэд хэцүү ажээ.

Гэвч буддын шашин нь хүмүүсийн хүслийг хааж, эгэл ард түмэн амьдралаа хамгаалах үзлийг үгүй болгож, эрх баригч ангийн төлөө үйлчилж, ингэж ард түмний үзэл бодлыг хязгаарлах нь феодалын ноёрхолд ашигтай байсан тул Зүүн Жин болон өмнөд Чао-гын ихэнх хаад буддын шашныг эрхэмлэж, Лиан хааны Сяо Янь-ны үед буддизм хятадад өргөн дэлгэрч оргилдоо хүрчээ. Сяо Янь нь төрийн ороо бусгаа шалтгааныг дүгнэн хэлэхдээ: "Шинэ улсаа байгуулалцаж буй төрийн түшээд болон ард түмэн бурхны шашныг нэн тэргүүнд тавьж, түүний ашиг тустай байдал болон үзэл санааг эрж хайж зохицуул" хэмээжээ.

Эндээс үзвэл, Сяо Янь нь нэг талаар Күнзийн сургаалыг ихэд хүндлэн эрхэмлэж, нөгөө талаар буддын шашинг түгээн дэлгэрүүлэхийг уриалж байсан нэгэн юм. \*Лиан улсын бичиг – Уг тэмдэглэл\*-д өгүүлснээр, Сяо Яньма нь буддын шашинд итгэдэг нэгэн байсан гэдэг. Нийт 100 гаруй буддын ном судрыг тэрээр орчуулж, буддын ном судар унших зав чөлөөнд, бас ямагт бурхан багшийн сургаал айлддаг байжээ. Олон мянган нэр хүндтэй лам, эрдэмтэн мэргэд түүний гэрт хүрэлцэн очдог. Тэрээр буддизмийн талаар 500 гаруй ном судрыг бичиж туурвисан ажээ.

Эрх баригч ангийн чухалчилснаар, өмнөд Чаод буддын шашин ихээр мандаж эхэлсэн. Нэг хошуунд 1000 гаруй сүсэгтэнтэй, тэдгээр хүмүүс нь бүх л бие сэтгэлээ шашинд зориулсан нь олонхи байсан.

Буддын сүм хийдийн эдийн засаг хүчирхэгжсэнээр, феодал засаглалт улсууд хүн ам, газар нутгийн хяналт суларч, феодалын ноёрхолд ашиггүй болж, улсын сан хөмрөг хойшилж эхэлсэн. Иймд эрх баригчид нь буддын шашинг олон удаа хориглож, түүнчлэн хожуу Вэй улсын Тай хаан, хойд Жоу улсын хаан болон Жоу Ши нар гурван удаа хатуу хориглож байсан.

Тай хаан нь бомбын шашинтай байсан. Тэрээр их сайд Цуй Хао-ын саналыг сонсоод буддын шашныг устгахаар болсон. Хожуу Вэй улсын үед Тай хаан Жан Ань хот руу дөрвөн удаа довтлон дайтаж, лам хуврагуудыг устган, бурхны хөргийг шатааж, Жан Ань хотын лам хуврагуудыг хороосон гэдэг. Энэхүү дайн нь буддын шашинд ноцтой хохирол учруулж, гагцхүү том тушаалын хүмүүсийн өмгөөллөөрүлдсэн буй. Тай хаан өөрийн биеэр, мөхсөн буддын шашны сүм хийдийн эдийн засгийн сүр хүчийг сэргээж, буддын шашны асар их сүр хүчийг хойд Вэй улсад бий болгосон.

Вэй улсын сүүл үед зүүн болон баруун Вэй дайны самуунаар буддын шашны сүр хүч хэдийгээр цохилтонд өртсөн боловч нэг талаар үймээн самуун болсон нь буддын шашны өргөжих хүрээг нэмэгдүүлсэн байна. Хойд улсын хаан бат бэх феодалын улс гүрнүүдийн шинэчлэлийн явцад буддын шашинг хориглох шат дараалсан уриалга хийсээр гурван сая хүнийг чөлөөлсөн түүхтэй. Буддын шашинг устгах дээрх хоёр удаагийн үйл хэрэг Вэй, Жин, Өмнөд Чао улсад өрнөж байх үед Тай хааны дараа буддын шашны сүр хүч хэд дахин нэмэгдсэн байна.

Жоу улсын Ү Ди хаан буддын шашныг мөхөөсний дараа, Янь Жэн хааны анхдугаар онд улс даяар хувраг болж болно гэсэн зарлиг буулгасан. Гэвч хүн амын тоонд үндэслэн хот болон Bing zhou, Luo zhou зэрэг том хотуудад ном судар бичиж, сүм хийдэд тарааж, мөн үүнээс гадна хуулан бичсэн ном судраа нууц газар хадгалах болсон байна. Улсын бүх хүн энэ аргад суралцаж ард түмний дунд бурханы сургаал болон \*Күнзийн зургаан боть\*-ыг харьцангуй их хэвлэн тараах болсон.

Тухайн үед "Буддын шашин Хятадын нөхцөл байдалд тохирохгүй. Энэтхэгийн шинж байдлыг хадгалсан" хэмээн шүүмжлэгдэж байсан бөгөөд

үргэлж олон түмний дунд тэрч байтугай эрх баригч ангийн зүгээс ихээр цагдан хориглож, зарлиг тушаал гаргасаар атал буддизм дэлгэрэх явдлыг зогсоож чадаагүй болно. Энэ нь ямар учиртайг бодож үзвэл, хүний амьдралын утга учир, хүмүүсийн зовлон зүдгүүр хүсэл эрмэлзлийн шалтгаан, үр дагавар, зовлонгоос ангижрах арга замыг бурхан багшийн сургаалд тодорхой өгүүлсэн байдаг нь хүмүүсийн итгэн бишрэхэд хүргэсэн байна.

Тан улсын дараа буддын шашин нь улс төр нийгмийн давхаргын дарангуйлах хэрэгсэл болсон бөгөөд Күнзийн сургаалыг бүдгэрүүлсэн. Тан улсын Тай Зун хаан буддын шашны ном судрыг ойлгодоггүй байсан хэдий ч буддын шашны суртал гүн нэвтэрч, буддын шашны арга барилыг багшаас суралцаж болно гэж үзэж байсан. Хувраг нь Тай Зун хаанаас эхлэн онцгой ёслолыг үйлдэж, бурханы хутагийг олох нь тухайн үед боломжгүй байсан. Тан улсын Ү Зун хаан бумбын шашин шүтдэг байсан бөгөөд бурханы шашныг хязгаарлаж, 265000 лам хуврагыг хар болгож, мянга мянган газрыг хураан авсан. Энэ нь феодалын засаглалт улс бурханы шашныг ялсан хэрэг байлаа.

Тан улсын дунд үеэс хойш Тай Зун хаан буддын шашныг туйлаар чухалчлан дэлгэрүүлэхэд анхаарч, буддын шашны ном судрыг дахин бичиж хэвлүүлэн Тан улсын үеэс төрийн түшмэлүүдийн үзэл санаанд нэвтэрсэн бурханы сургаал номлол нэгэн үеийг эзэлсэн. Хуврагуудын тоо ихэссэн. Гэвч энэ нь 300000 хүнээс хэтрээгүй. Буддын шашин энэ үеэс эхлэн хятадад дахин шинээр сэргэн мандсан.

Дээр дурдснаас үзэхэд буддын шашин хятадад нэвтэрснээс хойш удаа дараа мандан буурч ирсэн нь эрх баригч ангийн сонирхолтой маш их хамааралтай. Буддын шашин анх эрх баригчдын ноёрхох санааг хангахын төлөө байсан бөгөөд түүхэн хугацаанд удаа дараа бууран бөхөж ирсэн нь буддын шашны хөгжлийг сааруулах гэсэн хэрэг биш, харин ч эзэн хааны засаглалыг бэхжүүлэхийн төлөө хэрэгсэл болж байсан ажээ. Энэ бүхнээс үзвэл, эрх баригчид буддын шашныг зөвхөн нэгэн зүйлийн өөрийн ашиг сонирхолыг хангах хэрэгсэл болгож байсныг хялбархан олж харж болно.

Үргэлжлэл бий.